

**НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ  
ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5
<b>1. 1.Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг сайжруулах, мэргэжил,мэргэшил, мэдлэг чадварыг эзэмших тасралтгүй хөгжүүлэх</b>				
1	Боловсрол	1.1.1 Төрийн албан хаагчдын манлайлал, ур чадварыг дээшлүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх	<p>Тайлант хугацаанд 24 удаагийн сургалтад давхардсан тоогоор 525 ажилтан, албан хаагч хамрагдсан. Мөн дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 59 удаагийн сургалтад давхардсан тоогоор 797 албан хаагчийг ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулснаас 10 удаагийн сертификаттай сургалтад давхардсан тоогоор 92 албан хаагчийг хамруулсан.</p> <p>Төрийн албан хаагчдын манлайлал, ур чадварыг дээшлүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр 51 удаагийн танхим болон цахим сургалтад давхардсан тоогоор 510 албан хаагч хамрагдсан байна. Эдгээр сургалтын 7 удаагийн сургалт нь сертификаттай сургалт байсан байлаа.</p> <p>Байгууллагаас холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтууд: Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Монголын стандарт, чанарын хүрээлэнгээс зохион байгуулсан Чанарын менежментийн шинэ хандлага” сэдэвт сургалтад 1;</li> <li>2. Horeca Institute-ээс зохион байгуулсан “Зочлох үйлчилгээ ба манлайлал” сургалтад албан хаагч - 2;</li> <li>3. МҮЭХ-ны Залуучуудын хорооноос зохион байгуулсан “Хөдөлмөрийн эрүүл ахуй ба ковид-19” сургалтад албан хаагч - 20;</li> <li>4. Гэр өргөө ТББ-аас зохион байгуулсан “Бүтээлч сэтгэлгээ ба инновацийн өдөр” сургалтад ажилтан, албан хаагч - 56;</li> <li>5. МҮЭХ-ны Залуучуудын хорооноос зохион байгуулсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого ба залуучууд” сургалтад ажилтан, албан хаагч - 20;</li> <li>6. Си ди си консалтинг сургалтын төвөөс зохион байгуулсан “Журам боловсруулах аргачлал” сургалтад албан хаагч - 3;</li> <li>7. МҮЭХ-ны Залуучуудын хороо, ХБНГУ-ын ФЭС-тай хамтран зохион байгуулсан “ХАБЭА-ийн өнөөгийн байдал, цаашдын бодлого чиглэл” цахим сургалтад албан хаагч - 11</li> <li>8. Коронавируст /Ковид-19/ халдварын өвчлөл буурахгүй байгаатай холбоотойгоор их эмч Н.Энхзаяа 2021 оны 05 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд албан хаагчдад Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 7-ны тушаалаар коронавируст халдварын эсрэг вакцины дархлаажуулалтад нэмэлт зохицуулалт оруулсан талаарх мэдээлэл болон “Коронавирус /Ковид-19/-ээс урьдчилан сэргийлэх дасгал хөдөлгөөнөөр дархлаа сайжруулах” чиглэлээр зөвлөгөөг хүргэх сургалтад албан хаагч-45;</li> <li>9. НОБГ-тай хамтран зохион байгуулсан “Гамшиг осол, галын аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар зөвлөмж өгөх нь” сургалт</li> <li>10. “Газар хөдлөлтийн үеийн хариу арга хэмжээ, аюулгүй ажиллагаа болон газар хөдлөлтийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах вэ” сэдэвт сургалтад ажилтан, албан хаагч – 50;</li> <li>11. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын ариутгал халдваргүйжүүлэлтийн холбоо ТББ-тай хамтран зохион байгуулсан “Цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, халдварын сэргийлэлт,</li> </ol>	100%

1	2	3	4	5
1	Боловсрол		<p>хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх” сэдэвт сургалтад ажилтан, албан хаагч – 50;</p> <p>12. НЗДТГ-ын Сургалт судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан “Зөрчлийг удирдахуй” сэдэвт сургалтад албан хаагч - 34;</p> <p>13. НЗДТГ-ын Сургалт судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан “ERP системийн хэрэглээ” сэдэвт сургалтад албан хаагч - 16;</p> <p>14. Нийслэлийн цагдаагийн удирдах газартай хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ” сэдэвт сургалтад албан хаагч - 30;</p> <p>15. Нийслэлийн сургалт судалгааны төвтэй хамтран Экселийн анхан, дунд шатны сургалт-22</p> <p>16. ЗАА, Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хүрээлэнтэй хамтран 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр цахимаар зохион байгуулсан “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах” сэдэвт сургалтад ажилтан, албан хаагч - 118;</p> <p>17. Монголын цахим институт ТББ-аас 2021 оны 12 дугаар сарын 01-30-ны өдрийн хугацаанд зохион байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан бэлтгэх ХАБЭА-н ажилтны ажиллах эрхийн хугацаагүй лицензтэй сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулсан.</p> <p>18. Засгийн газрын байруудын үйлчилгээний албанаас 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан “Чанарын өдөрлөг”-т оролцон туршлага судалсан.</p> <p>Дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан бэлтгэх сургалтаар албан хаагч -1;</li> <li>2. “Зөв менежмент- Зөв тогтолцоо” стандарт танилцуулах сургалтад -24;</li> <li>3. “Чанарын менежментийн шинэ хандлага” сэдэвт сургалтаар албан хаагч -1;</li> <li>4. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулж буй</li> <li>5. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлах, түүнийг тайлагнах, үнэлэхтэй холбоотой 4 модульд сургалтад- 45;</li> <li>6. “Цагийн менежмент” сургалтад -2;</li> <li>7. “Төслийн удирдлагын үндэс” сургалтад -7;</li> <li>8. “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан” бэлтгэх сертификаттай сургалтад 1;</li> <li>9. “Алсын хараа 2050” богино хугацааны сургалтад 9 албан хаагч тус тус хамрагдаж сертификат гардан авсан.</li> <li>10. Сангийн яам Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан “Худалдан авах ажиллагаатай холбоотой шинэчилсэн журам, тендерийн жишиг баримт бичиг, цахим системийн танилцуулга” цахим сургалт;</li> <li>11. НЗДТГ-ын ХЭЗХ-с зохион байгуулсан “МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг танилцуулах, “Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орж байгаа талаар онлайн сургалт</li> <li>12. Нийслэлийн сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан “Хүйсийн тэгш байдлын төлөөх төрийн албан хаагчийн манлайлал” цахим сургалт;</li> </ol> <p>“Хөдөлмөрийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын танилцуулга, Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан ublegal.mn сайтыг танилцуулга” арга зүйн цахим сургалт;</p>	100%

1	2	3	4	5
1	Боловсрол	1.1.1 Төрийн албан хаагчдын манлайлал, ур чадварыг дээшлүүлэх, харилцаа хандлагыг сайжруулах, ёс зүй, хариуцлагыг өндөржүүлэх	<p>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. "Хүний нөөцийн удирдлагын тогтолцоо" цахим системийн онлайн сургалт;</li> <li>2. "Төрийн үйлчилгээний чанар" цахим сургалт;</li> <li>3. "Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт ба төрийн албаны шинэтгэл" цахим сургалт;</li> <li>4. "Зан үйлд нөлөөлөх ухааныг төрийн бодлогод ашиглах нь" цахим сургалт;</li> <li>5. "Судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл" цахим сургалт;</li> <li>6. Албан хаагчийн зөөлөн ур чадвар хөгжүүлэх туршлага" арга зүйн цахим сургалт;</li> <li>7. "Майер Бригсийн төрөл илтгэгч " арга зүйн цахим сургалт;</li> <li>8. "Төрийн албан хаагчийн хэрэг хөтлөх журам" (шинэчилсэн найруулга) төслийн хэлэлцүүлэг хийх арга зүйн цахим хөтөлбөр.</li> <li>9. "Харилцааны ур чадвар" цахим сургалт;</li> <li>10. "Төрийн албан хаагчийн хэрэг хөтлөх журам" (шинэчилсэн найруулга) төслийн хэлэлцүүлэг хийх арга зүйн цахим хөтөлбөр.</li> <li>11. "Албан хаагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх нь" цахим сургалт</li> <li>12. "Нийтийн салбарын стратегийн удирдлага" арга зүйн цахим сургалт;</li> <li>13. "Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын тухай болон төрийн албаны сонгон шалгаруулалтын тусгай журмын тухай хуулийн төслүүдийн талаарх цахим хэлэлцүүлгийн" цахим сургалт;</li> <li>14. "Төрийн албан хаагчийн манлайлал" арга зүйн цахим сургалт;</li> <li>15. "Төрийн захиргаанаас нийтийн удирдлагад" цахим сургалт</li> <li>16. "Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ба төрийн албаны шинэтгэл" арга зүйн цахим сургалт;</li> <li>17. "Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, (шинэчилсэн найруулга)-ын зорилт, зохицуулах харилцаа" арга зүйн цахим сургалт;</li> <li>18. "Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга" арга зүйн цахим сургалт;</li> <li>19. "Төрийн албаны сонгон шалгаруулалтын өнөөгийн байдал" арга зүйн цахим сургалт;</li> <li>20. "Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, анхаарах асуудал" сэдэвт цахим сургалт;</li> <li>21. "Харилцан хүндэтгэл, итгэлцэл бүхий орчинг бүрдүүлэх нь" цахим сургалт;</li> </ol>	100%
1	Боловсрол	1.1.2 Баримт бичиг боловсруулах, архив, албан хэрэг хөтлөх ур чадварыг сайжруулах сургалт	<p>Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын баримт бичиг боловсруулах, архив, албан хэрэг хөтлөх ур чадварыг сайжруулах сургалт чиглэлээр 7 удаагийн сургалтын 3 сургалт нь сертификаттай, сургалтад давхардсан тоогоор 91 албан хаагчийг хамруулсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ "Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй" сэдэвт сургалтад 1;</li> <li>✓ "Төрийн архивын баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх, нөхөн бүрдүүлэлтээр баримт хүлээн авах, данс, бүртгэл үйлдэх арга зүйн" сургалтад 1;</li> <li>✓ "Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй" сургалтад 1;</li> <li>✓ Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албаны тухай болон архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт" арга зүйн цахим сургалт;</li> <li>✓ Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн Edoc систем" цахим сургалт;</li> <li>✓ Нийслэлийн сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан "Ms excel" цахим сургалт;</li> <li>✓ Нийслэлийн сургалт судалгааны төвтэй хамтран Экселийн анхан, дунд шатны сургалтыг зохион байгуулан ажиллалаа.</li> </ul>	100%
		1.1.3 Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001 стандарт	<p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Монголын стандарт, чанарын хүрээлэнгээс зохион байгуулсан "Чанарын менежментийн шинэ</li> </ul>	

1	2	3	4	5
1	Боловсрол	нэвтрүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>✓ хандлага” сэдэвт цахим сертификаттай сургалтад 1;</li> <li>✓ “Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг байгууллагын ажиллагаанд нэвтрүүлэх ач холбогдол, үр дүн” цахим сургалт -6;</li> <li>✓ Засгийн газрын байруудын үйлчилгээний албанаас зохион байгуулсан “Чанарын өдөрлөг” сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдсан.</li> </ul>	
		1.1.4 Монгол бичиг, монгол хэлний зөв бичих дүрэм, найруулга зүйн тухай ойлголт сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	<p>Тайлант хугацаанд Нийслэлийн сургалт судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан “Монгол хэлний зөв бичих дүрэм, найруулга зүй” сургалтад 32 албан хаагч хамрагдсан.</p> <p>Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын монгол бичгийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор монгол бичгийн анхан шатны сургалтыг “Монгол бичгээ сурцгаая” уриатайгаар видео хэлбэрээр 3, танхимаар 7 удаа нийт 130 ажилтан, албан хаагчдад сургалт зохион байгуулж ажиллалаа.</p> <p>Төрийн албан хэргийг 2025 оноос кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын монгол бичгийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор монгол бичгийн анхан шатны сургалтыг “Монгол бичгээ сурцгаая” уриатайгаар видео хэлбэрээр бэлтгэж, байгууллагын группэд байршуулсан.</p>	100%
		1.1.5 Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалд тавигдах шаардлага сургалт	<p>Нийслэлийн 2021-2024 оны стратеги төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг аргачлал, загвар маягтын дагуу боловсруулах ажлын хэсгийг газрын даргын 2021 оны А/45 дугаар тушаалаар баталсан. Менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Пи Эм Си Жи” ХХК-тай хамтран зохион байгуулан “Стратеги төлөвлөлтийн үндсэн ойлголт” сэдэвт сургалтад 10 албан хаагч хамрагдлаа.</p>	
		1.1.6 Төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүй, харьцаа хандлагыг дээшлүүлэх сургалт	<p>Тайлант хугацаанд байгууллагын ёс зүйн дүрмийг ажилтан, албан хаагчдад сурталчлан ажилласан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан :</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ “Албан хаагчийн зөөлөн ур чадвар хөгжүүлэх туршлага” арга зүйн цахим сургалт;</li> <li>➢ “Харилцан хүндэтгэл, итгэлцэл бүхий орчинг бүрдүүлэх нь” цахим сургалт;</li> <li>➢ “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын тухай болон төрийн албаны сонгон шалгаруулалтын тусгай журмын тухай хуулийн төслүүдийн талаарх цахим хэлэлцүүлгийн” цахим сургалт</li> <li>➢ “Төрийн албан хаагчийн манлайлал” арга зүйн цахим сургалт;</li> <li>➢ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “Хүний эрх ба ялгаварлан гадуурхалт” цахим сургалт;</li> <li>➢ Ажилтан, албан хаагчдыг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор “Сайхан харилцаа, тайван амьдрал” сэдэвт сургалтад байгууллагын 147 ажилтан, албан хаагчдыг хамруулан ажиллалаа.</li> </ul>	
		1.1.7 Тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын мэргэшил дээшлүүлэх сургалтад сурах бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлэх	<p>Байгууллагын хэмжээнд Хүмүүнлэгийн Ухааны их сургуульд хэл шинжлэлийн магистрантурт 1, Удирдлагын академид төрийн удирдлагын магистрантурт 2, Олон улсын Улаанбаатар их сургуульд эрх зүйн магистрантурт 1, МУИС-д хүний нөөцийн ажилтнаар магистрантурт 1, Санхүү, эдийн засгийн их сургуульд бизнесийн удирдлагаар магистрантурт 1, Хөдөлмөр нийгмийн хамгааллын дээд сургуулийн ХАБЭА бакалаврт 1, ХААИС-ийн газар зохион байгуулалтын бакалаврт нийт 8 албан хаагч хувийн зардлаараа суралцаж байна.</p>	
1.1.8 Шинээр томилогдон ажилтан, албан хаагчдад ёс зүйн дүрэм, холбогдох хууль тогтоомж, албан тушаалын	<p>Шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад байгууллагын ёс зүйн дүрэм болон холбогдох хууль тогтоомжууд, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг танилцуулан үйлчилгээний ажилтнуудад “Цэвэрлэгээ үйлчилгээний тавигдах ерөнхий шаардлага стандарт, харилцаа хандлага, ёс</p>			

1	2	3	4	5
1	Боловсрол	тодорхойлолтод заасан чиг үүргийг таниулах, ажлын байранд сургах сургалт зохион байгуулах	зүйн” сургалтыг байр тус бүрээр танхимын сургалтыг зохион байгуулж ажиллалаа.	100%
		1.1.9 Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, шинэчлэл, стандартын талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулах	Тайлант хугацаанд хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг, шинэчлэлтэй холбоотой сургалтад захиргааны 46 албан хаагчдыг хамруулсан. Үүнд: 1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан байгуулсан “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга”, “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга”, “Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан ublegal.mn сайтыг танилцуулга” арга зүйн цахим сургалтад; 2. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, (шинэчилсэн найруулга)-ын зорилт, зохицуулах харилцаа” арга зүйн цахим сургалтад 46; 3. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга сургалтуудад тус тус хамрагдсан. 4. “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” UCS 0202B:2020 стандарт удирдамж арга зүйн баримт бичгийг нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын цэвэрлэгээ үйлчилгээ хариуцсан аж ахуйн нэгж, тасгийн ажилтан, албан хаагчдад таниулах сургалт семинарыг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулсан.	
		1.1.10 Судалгааны арга зүй, дотоод хяналтыг сайжруулах чиглэлийн сургалтад хамруулах	Дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 4 удаагийн сургалтад ажилын чиг үүргийн дагуу албан хаагчдыг хамруулсан. Үүнд: 1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлал, загварыг танилцуулах сургалтад 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр 45; 2. Төрийн албаны зөвлөлөөс 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан “Судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл” сургалт 45; 3. НӨАУГ-аас 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Нийслэлийн өмчийн хөрөнгийн хөдөлгөөнийг зохицуулах журам, тогтоол шийдвэрийн хэрэгжилт төрийн байгууллагуудын өмчийн харилцаа ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, өдөр тутамд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх талаар зөвлөгөө, сургалтад 18; 4. Төрийн албаны зөвлөлөөс зохион 2021 оны 03 дугаар сарын 18-ны 1.2 Удирдах албан хаагчдын манлайлалын чадварыг хөгжүүлэх	
1.2.1. Удирдах албан тушаалтануудыг төрийн албаны манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх сургалтад хамруулах	Тайлант хугацаанд удирдах албан тушаалтнууд дараах сургалтад хамрагдсан. Үүнд: НЗДТГ-аас зохион байгуулсан: - Мэдүүлэг гаргагч албан тушаалтанд зориулсан сургалт 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр 1 албан хаагч; - “Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагийн хэлтсийн дарга нарт зориулсан багц сургалт”-д 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 3 албан хаагч; - Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн	100%		

1	2	3	4	5
			"найруулга" сургалт 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр 3 албан хаагчид тус тус хамрагдсан.	
		1.2.2 Удирдах албан тушаалтны ёс зүйн дүрмийг сурталчлан таниулах, мөрдүүлэх, үнэлэх талаар удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, Төсвийн шууд захирагчаас нэгжийн дарга нартай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд манлайллын шалгуур үзүүлэлт, манлайлах үр чадварт өгөх үнэлгээг тусгах	Нэгжийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд манлайллын чиглэлээр хийх арга хэмжээг тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн зөвлөл нь ажилтан, албан хаагчдыг гэмт хэрэг зөрчлөөс урьчилан сэргийлж, холбогдох хууль, тогтоомжийг сурталчилан ажиллалаа.	100%
<b>2.1 Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах</b>				
2	Эрүүл мэнд	2.1.1. Жил бүр ажилтан, албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эмчилгээ хийлгэх боломж олгох	Тайлант хугацаанд: <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд "Оюу шүр мед" эмнэлэгтэй хамтран нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 250 ажилтан, албан хаагчийг хамруулсан.</li> <li>- ЧДЭМТ-ийн нян судлалын лабораторитой хамтран 2021 оны 2, 10 дугаар сард зоогийн газрын тогооч, зөөгч, бэлтгэгч, угаагч 29 ажилтныг 2 удаа эрүүл мэндийн шинжилгээнд хамрууллаа.</li> <li>- Нийгмийн хариуцлагын хүрээнд сайн дурын, авлагагүй, цусны донорын эгнээг өргөжүүлэх, цусны донорын үйлсийг сурталчлах, тэднийг алдаршуулж урамшуулах зорилгоор Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран "Цусаа бэлэглэе" аяныг 2021 оны 12 дугаар сарын 03-23-ны өдрүүдэд зохион байгууллалаа. Тус аянд нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчид сайн үйлсийн аянд нэгдэн идэвхтэй хамрагдлаа.</li> </ul>	90%
		2.1.2. Байгууллагын биеийн тамир спортын хамтлаг нь нийтийн биеийн тамирыг сурталчлах ажилтан, албан хаагчдыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны боловсрол олгох, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх чиглэлээр ажил зохион байгуулах	Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдөр "Гар бөмбөг"-ийн нөхөрсөг тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Тус хэмжээнд байгууллагын 16 баг 140 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцож, Г.Батзаяа ахлагчтай Захиргааны 3-р баг тэргүүлж алтан медаль, А.Нямсүрэн ахлагчтай НЗЗ-ны 3-р байрны баг тамирчид мөнгөн медаль, Х.Долгормаа ахлагчтай НЗЗ-ны 2-р байрны баг тус тус шалгарсан. Биеийн тамир спорт хамтлаг нь цар тахлын үед ажилчдынхаа дархлааг дэмжиж, ажиллах урам зориг, эрч хүч бэлэглэх зорилгоор "Дархлаагаа дэмжиж эрч хүчтэй, эрүүл амьдарцгаая" уриатайгаар 300 ажилтан, албан хаагчдад дархлааны багц олгож ажиллалаа.	
		2.1.3. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг зохион байгуулах	Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан олон нийтийг хамарсан аливаа үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосон тул тус арга хэмжээг тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон байна.	
		2.1.4. Цасны баяр, явган аялалыг зохион байгуулах		
<b>2.2 Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх</b>				
	1. Албан хаагчдыг		- Байгууллагаас албан хаагчдын шаардлагатай компьютер, техник хэрэгсэл, мэдээллийн дотоод	

1	2	3	4	5		
3	Нийгмийн баталгаа	шаардлагатай компьютер, техник хэрэгсэл тоног төхөөрөмж ажлын өрөөгөөр хангаж, мэдээллийн дотоод сүлжээний найдвартай аюулгүй ажиллагааг тогтмол хангах	сүлжээний програм хангамжийн аюулгүй ажиллагааг ханган ажилласан. - Цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг сайжруулах үүднээс цэвэрлэгээний багаж, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, үе шаттайгаар шинэчлэлт сайжруулалтын ажлыг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд 10 тоос сорогч, өндрийн цэвэрлэгээнд хэрэглэх 8 шат, өвлийн цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэгтэй гадна талбайн багаж, хөлтэй халуун хэмжигч 10, мананцар үүсгэгч 10, цэвэрлэгээний тэргэнцэр 4, тоос сорогч 2 өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай 21 төрлийн 732 ширхэг багаж зэрэг эд материалаар хангаж ажиллалаа.	100%		
		2.Үйлчилгээний ажилчдад ажлын хувцас, шаардлагатай эд материалаар хангаж ажиллах	Тайлант хугацаанд гадна талбайн үйлчлэгчийн 11, байрны жижүүрийн 18, зөөгчийн ёслолын 16, үйлчлэгчийн 80, сантехникийн слесарь, мужаан, цахилгаанчны 41 ширхэг нормын хувцсыг тус тус шинэчлэн олгож ажилласан байна.			
		3.1 Амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах				
		3.1.1. Ажилтан, албан хаагчдын өргөдөл хүсэлтийг үндэслэн төрийн байгууллагад ажилласан хугацаа, ажлын үр дүн, амьдралын нөхцөл байдал зэргийг харгалзан хөнгөлөлттэй зээл тусламж, орон сууцжуулах хөтөлбөр, хөнгөлөлтөд хамруулах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тус байгууллагад олон жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа өрх толгойлсон болон амьдралын боломж муутай 2 ажилтанд иж бүрэн гэрийг шийдвэрлэн өгсөн.	100%		
		3.1.2. Ажилтан, албан хаагчдад хоол, унааны зардлын зохих хэсгийг олгох	Ажилтан, албан хаагчдад 2021 онд 131.063.500 төгрөгийг унаа, хоолны зардал олгосон байна.			
		3.2 Төрийн албан хаагчид үзүүлэх урамшуулал, тусламж, тэтгэмж				
3.2.1 Өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтан, албан хаагчдад Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолын дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох	Өндөр насны тэтгэвэрт гарч буй 2 ажилтанд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолыг үндэслэн өндөр насны тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн буцалтгүй тусламж 44,508,131 төгрөгийг олгосон байна.					
3.2.2 Ажилтан, албан хаагчдын гэр бүлийн гишүүн (эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг, эх) нас барсан тохиолдолд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 34 ажилтан, албан хаагчдад 8,176,566 төгрөгний буцалтгүй тусламж олгосон.	100%				
3.2.3 Ажлын бүтээмж, үр дүнг холбогдох журмын хүрээнд улирал бүр үнэлж дүгнэн ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал олгох	Ажилтан албан хаагчдын ажлыг улирлаар дүгнэн давхардан тоогоор 275 ажилтан, албан хаагчдад 225.714.062 төгрөгийн үр дүнгийн урамшуулал, 212.415.424 төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.					

1	2	3	4	5
3	Нийгмийн баталгаа	3.2.4 Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гаргаж үүргээ бүрэн биелүүлж амжилт гаргасан ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулах, төрийн дээд одон медаль бусад шагналд тодорхойлох	Эрхэлсэн ажилдаа тогтвор суурьшилтай, ажилдаа амжилт гаргасан ажилтан албан хаагчдыг судлан төрийн болон яам, НИТХ, НЗД-ын шагналын журмын дагуу тодорхойлон холбогдох дээд байгууллагуудад материалыг хүргүүлж шагнаж урамшуулсан байна. Үүнд: Төрийн дээд одон медалиар 3, МУ-ын Засгийн газар, яамдын шагналаар 24, ТЗҮЭГазрын шагналаар 2, НИТХ-ын шагналаар 26, НЗД-ын шагналаар 19 нийт 74 ажилтан, албан хаагч шагнагдсан.	100%
		3.2.5 Ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг хуулинд нийцүүлэн олгох	Газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар баталсан хуваарийн дагуу 264 ажилтан, албан хаагчдад ээлжийн амралтыг биеэр нь эдлүүлсэн.	100%
		3.2.6 Ажилтан, адбан хаагчдын илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг зохих хууль, журмын дагуу тухай бүр үндсэн цалингаас нь тооцож олгох	Илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг зохих хууль, журмын дагуу 275 ажилтан, албан хаагчид нийт 210.299.849 төгрөгний нэмэгдэл хөлсийг тухай бүр олгож ажилласан.	100%
		3.2.7 Ажилтан, адбан хаагчдад төрийн байгууллагад ажилласан хугацааны нэмэгдлийг тооцож олгох	Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын дагуу 212.415.424 төгрөгийг ажилтан, албан хаагчийг төрийн албанд ажилласан жилийн судалгааг гарган төрийн байгууллагад ажилласан хугацааны нэмэгдлийг зохих журмын дагуу олгосон байна.	100%
		3.2.8 Ажилтан, албан хаагчдын амьдрал ахуйд нь хүнд нөхцөл байдал үүссэн тохиолдолд дэмжлэг үзүүлэх	Дэм дэмэндээ" аянд нэгдэж коронавируст цар тахлын хүнд нөхцөл байдлын үед ажлын байр нь түр хаагдсан, орлого нь тасарсан айл өрхүүдэд тусламж үзүүлэх зорилгоор хүнсний тусламжийг СХД-н 4, 26, 36 хороодын 80 өрх, байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад, ажилтан албан хаагчдаас 40 өрх нийт 120 өрхэд байгууллагын удирдлагууд болон захиргааны албан хаагчдын төлөөлөл 2021 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр халдвар, хамгааллын дэглэмийг баримтлан тусламжийг гэрт нь хүргэж ажилласан. Мөн байгууллагын өрх толгойлсон эх, эцэг болон олон хүүхэдтэй 15 ажилтанд хүнсний тусламж үзүүлж ажиллалаа.	100%

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

 Ч.ШИНЭЧИМЭГ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН  
ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН  Н.БУЛГАНЧИМЭГ